

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Могойн бага сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99039344 Цахим хаяг:
mandaxnaranl@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/247
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН МОГОЙН
БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЛХАГВАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Могойн бага сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс олгох санхүүжилтийн дүнг 16,699.6 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4,607.6 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Цэцэрлэг сумын Могойн бага сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	194,676,133.49	210,903,664.36
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Банкинд байгаа бэлэн мөнгө	87,640,331.21	94,831,951.05
Төгрөг	87,640,331.21	94,831,951.05
Төрийн сангийн харилцах	87,640,331.21	94,831,951.05
АВЛАГА	00.00	1,911,579.91
Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,911,579.91
БАРАА МАТЕРИАЛ	107,035,802.28	114,160,133.40
Түүхий эд материал	22,303,460.00	22,303,460.00
Тусгай зориулалттай материал	21,400,960.00	21,400,960.00
Эм боох материал	902,500.00	902,500.00
Хангамжийн материал	84,732,342.28	91,856,673.40
Бичиг хэргийн материал	901,820.00	298,000.00
Аж ахуйн материал	88,500.00	607,000.00
Түлш, шатах тослох материал	1,015,000.00	1,015,000.00
Барилгын засварын материал	968,520.00	968,520.00
Хүнсний материал	10,507,630.00	17,356,720.00
Бусад хангамжийн материал	71,250,872.28	71,611,433.40
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	510,377,740.88	497,811,824.81
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	510,377,740.88	497,811,824.81
Биет хөрөнгө	476,303,740.88	463,737,824.81
Барилга, байгууламж, орон сууц	316,632,548.00	360,608,821.00
Хуримтлагдсан элэгдэл	-64,222,239.08	-78,199,732.56
Машин тоног төхөөрөмж (компьютер)	217,079,922.00	222,005,322.00
Хуримтлагдсан элэгдэл	-49,089,397.43	-93,762,175.53
Тавилга, аж ахуйн эд хогшил	56,803,868.72	56,803,868.72
Хуримтлагдсан элэгдэл	-24,135,635.43	-29,543,522.88
Бусад үндсэн хөрөнгө	4,408,160.00	5,947,810.00
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-564,080.04
Ном	18,826,514.10	20,441,514.10
Биет бус хөрөнгө	34,074,000.00	34,074,000.00
Бусад биет бус хөрөнгө	34,074,000.00	34,074,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	705,053,874.37	708,715,489.17
НИЙТ ӨР ТӨЛБӨР	99,251,419.08	69,604,390.80
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,251,419.08	69,604,390.80
Өглөг	99,251,419.08	69,604,390.80
Ажилчидтай холбогдсон өглөг	5,002,228.28	00.00
Бусад өглөг	94,249,190.80	69,604,390.80
Байгууллагад төлөх өглөг	94,249,190.80	69,604,390.80
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	605,802,455.29	639,111,098.37
Засгийн газрын хувь оролцоо	605,802,455.29	639,111,098.37
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,175,329.94	208,175,329.94
Өмч: - төрийн	208,175,329.94	208,175,329.94
Хуримтлагдсан үр дүн	281,661,875.17	314,970,518.25
Өмнөх үеийн үр дүн	281,661,875.17	281,661,875.17
Тайлант үеийн үр дүн	00.00	33,308,643.08
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115,965,250.18	115,965,250.18
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	705,053,874.37	708,715,489.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	791,411,467.84	745,436,734.12
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,517,067.84	46,157,334.12
Нийтлэг татварын бус орлого	136,517,067.84	46,157,334.12
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	654,894,400.00	699,279,400.00
Улсын төвлөрсөн төсвөөс	622,633,600.00	652,817,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	622,633,600.00	652,817,400.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,260,800.00	46,462,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,260,800.00	46,462,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	573,044,237.45	712,128,091.04
УРСГАЛ ЗАРДАЛ	573,044,237.45	712,128,091.04
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,876,996.53	681,401,641.78
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	387,813,710.22	496,653,722.41
Үндсэн цалин	259,246,287.34	296,382,150.83
Нэмэгдэл	112,691,822.88	155,571,106.58
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	17,575,000.00
Урамшуулал	15,875,600.00	27,125,465.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,690,075.83	58,088,270.62
Тэтгэврийн даатгал	32,506,780.30	39,500,148.18
Тэтгэмжийн даатгал	3,807,555.52	4,646,805.07
ҮОМШӨ-ний даатгал	1,930,837.28	2,323,603.56
Ажилгүйдлийн даатгал	1,926,381.28	2,323,603.56
Эрүүл мэндийн даатгал	7,518,521.45	9,294,110.25
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,764,660.08	29,834,910.74
Гэрэл, цахилгаан	3,268,620.08	5,639,975.74
Түлш, халаалт	22,371,040.00	21,194,935.00
Цэвэр, бохир ус	1,125,000.00	3,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	2,431,150.00	4,044,170.00
Бичиг хэрэг	00.00	2,356,220.00
Тээвэр, шатахуун	1,917,850.00	1,687,950.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513,300.00	00.00
Нормативт зардал	11,050,880.00	13,449,530.00
Хоол, хүнс	11,050,880.00	13,449,530.00
Эд хогшил, урсгал засварын зардал	34,411,400.00	2,975,000.00
Урсгал засвар	34,411,400.00	2,975,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,567,684.80	5,503,798.94
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,567,684.80	5,503,798.94
Бараа үйлчилгээний бусад зардал	43,147,435.60	70,852,239.07
Бараа үйлчилгээний бусад зардал	4,128,031.77	6,230,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,852,600.00	00.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,166,803.83	64,622,239.07
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,167,240.92	30,726,449.26
Бусад урсгал шилжүүлэг	16,942,001.00	18,845,360.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,752,601.00	17,655,660.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,189,400.00	1,189,700.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,225,239.92	11,881,089.26
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,225,239.92	11,881,089.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	218,367,230.39	33,308,643.08
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	218,367,230.39	33,308,643.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,175,329.94	117,528,024.18	61,731,870.78	387,435,224.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,562,774.00	1,562,774.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,175,329.94	117,528,024.18	63,294,644.78	388,997,998.90
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	218,367,230.39	218,367,230.39
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,175,329.94	115,965,250.18	281,661,875.17	605,802,455.29
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,308,643.08	33,308,643.08
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,175,329.94	115,965,250.18	314,970,518.25	639,111,098.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	654,894,400.00	699,279,400.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	654,894,400.00	699,279,400.00
Улсын төвлөрсөн төсвөөс	622,633,600.00	652,817,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	622,633,600.00	652,817,400.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,260,800.00	46,462,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,260,800.00	46,462,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	520,507,558.54	685,926,180.16
УРСГАЛ ЗАРДАЛ	520,507,558.54	685,926,180.16
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	505,525,818.62	651,152,890.90
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,811,481.94	503,567,530.70
Үндсэн цалин	247,113,882.38	297,781,749.74
Нэмэгдэл	119,320,599.56	160,573,335.96
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	17,575,000.00
Урамшуулал	16,377,000.00	27,637,445.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,690,075.83	58,088,270.52
Тэтгэврийн даатгал	32,336,192.00	39,500,148.18
Тэтгэмжийн даатгал	3,940,969.83	4,646,805.07
ҮОМШӨ-ний даатгал	1,902,152.00	2,323,603.56
Ажилгүйдлийн даатгал	1,902,152.00	2,323,603.56

Эрүүл мэндийн даатгал	7,608,610.00	9,294,110.15
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,764,660.08	29,834,910.74
Гэрэл, цахилгаан	3,268,620.08	5,639,975.74
Түлш, халаалт	22,371,040.00	21,194,935.00
Цэвэр, бохир ус	1,125,000.00	3,000,000.00
Нормативт зардал	13,351,700.00	16,251,780.00
Хоол, хүнс	13,351,700.00	16,251,780.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,270,900.00	4,746,000.00
Урсгал засвар	4,270,900.00	4,746,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,983,725.77	5,503,798.94
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,983,725.77	5,503,798.94
Бараа үйлчилгээний бусад зардал	26,653,275.00	33,160,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	24,632,275.00	31,514,700.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,021,000.00	1,645,900.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,981,739.92	34,773,289.26
Бусад урсгал шилжүүлэг	13,756,500.00	22,892,200.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,567,100.00	21,702,500.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,189,400.00	1,189,700.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,225,239.92	11,881,089.26
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,225,239.92	11,881,089.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>134,386,841.46</u>	<u>13,353,219.84</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	95,646,106.00	6,161,600.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,646,106.00	6,161,600.00
Дотоод эх үүсвэрээр	95,646,106.00	6,161,600.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	95,646,106.00	6,161,600.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-95,646,106.00</u>	<u>-6,161,600.00</u>
НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,740,735.46	7,191,619.84
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	48,899,595.75	87,640,331.21
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	87,640,331.21	94,831,951.05

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	757,702,200.00	699,279,400.00	58,422,800.00	92.29
Улсын төсвөөс санхүүжих	669,517,000.00	652,817,400.00	16,699,600.00	97.51
Орон нутгийн төсвөөс	46,462,000.00	46,462,000.00	-	100.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	41,723,200.00	-	41,723,200.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	757,702,200.00	699,279,400.00	58,422,800.00	92.29
НИИТ ЗАРЛАГЫН ДҮН	757,702,200.00	692,087,780.16	65,614,419.84	91.34

Ажиллагчидтай холбогдсон зардал	615,841,800.00	561,655,801.22	54,185,998.78	91.20
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	547,414,800.00	503,567,530.70	43,847,269.30	91.99
Үндсэн цалин	309,641,200.00	297,781,749.74	11,859,450.26	96.17
Нэмэгдэл	207,173,400.00	160,573,335.96	46,600,064.04	77.51
Унаа, болон бусад нөхөн олговор	-	17,575,000.00	(17,575,000.00)	
Урамшуулал	30,600,200.00	27,637,445.00	2,962,755.00	90.32
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,427,000.00	58,088,270.52	10,338,729.48	84.89
Тэтгэврийн даатгал	46,530,300.00	39,500,148.18	7,030,151.82	84.89
Тэтгэмжийн даатгал	5,474,200.00	4,646,805.07	827,394.93	84.89
ҮОМШӨ ний даатгал	2,737,100.00	2,323,603.56	413,496.44	84.89
Ажилгүйдлийн даатгал	2,737,100.00	2,323,603.56	413,496.44	84.89
Эрүүл мэндийн даатгал	10,948,300.00	9,294,110.15	1,654,189.85	84.89
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,716,000.00	29,834,910.74	11,881,089.26	71.52
Гэрэл цахилгаан	4,000,000.00	5,639,975.74	(1,639,975.74)	141.00
Түлш, халаалт	34,416,000.00	21,194,935.00	13,221,065.00	61.58
Цэвэр, бохир ус	3,300,000.00	3,000,000.00	300,000.00	90.91
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	26,251,900.00	16,251,780.00	10,000,120.00	61.91
Хоол, хүнс	26,251,900.00	16,251,780.00	10,000,120.00	61.91
Бусад бараа үйлчилгээний зардал	51,000,300.00	49,571,998.94	1,428,301.06	97.20
Урсгал засвар	4,746,000.00	4,746,000.00	-	100.00
Мэдээллийн технологийн зардал	6,626,400.00	5,503,798.94	1,122,601.06	83.06
Бараа үйлчилгээний бусад зардал	37,322,000.00	37,016,300.00	(305,700.00)	100.95
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,305,900.00	1,645,900.00	(660,000.00)	71.38
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,892,200.00	34,773,289.26	(11,881,089.26)	151.90
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	21,702,500.00	21,702,500.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,189,700.00	1,189,700.00	-	100.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		11,881,089.26	(11,881,089.26)	
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	757,702,200.00	692,087,780.16	65,614,419.84	91.34
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		87,640,331.21	(87,640,331.21)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		94,831,951.05	(94,831,951.05)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 75,223.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 75,223.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайланг бэлтгэн ирүүлэхдээ санхүүгийн байдлын тайланд авлага, бараа материал, барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдлийг 46,521.8 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд орлого, зардлыг 28,701.8 мянган төгрөгөөр тус тус буруу тайлагнасан байна. .

Аудитаар нийт 546,500.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 546,500.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага хүргүүлээгүй

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Үр дүнгийн тайланд 3,448.5 мянган төгрөгийн урсгал засвар, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлыг эдийн засгийн ангиллаар нь зөв тайлагнаагүй нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай журам”-ыг зөрчсөн, “ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

1. Үр дүнгийн тайлангийн зардлуудыг эдийн засгийн ангиллаар зөв бүртгэж хэвших;

Илрүүлэлт:

2. Эд хариуцагч нь тайлант оны хүнсний материалын тайланг 509.2 мянган төгрөгийн алдаатай гаргасан, нягтлан бодогч нь эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.2-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байна” гэж заасныг зөрчсөн, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

2. Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох;

Илрүүлэлт:

3. Эд хариуцагч хүнсний материал зарцуулахдаа эхэлж авснаас эхэлж зарцуулах аргыг ашигладаггүйгээс өмнөх оны үлдэгдлээс 694.9 мянган төгрөгийн хүнс зарцуулаагүй үлдэж, хугацаа дууссан байгаа нь байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн мөрдөж ажиллаагүй, эрх ба үүрэг, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийн хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

3. Хүнсний материалыг зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарцуулах аргыг ашиглаж хэвших

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 343,876.9 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны тайланг 101,805.5 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 96,165.5 мянган төгрөгөөр тус тус дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5,-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан

байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

1. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгах гүй орхиг дуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	75,223.6			1	75,223.6	1	75,223.6				
Дүн	1	75,223.6			1	75,223.6	1	75,223.6				

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Эд хариуцагч нь тайлант оны хүнсний тайланг материалын зарлагыг цэсний дагуу гаргаагүй, алдаатай тайлагнасан. нягтлан бодогч шалгаж тооцоо бодоогүй байна	1	509.2						1	509.2
Эд хариуцагч хүнсний материал зарцуулахдаа эхэлж авснаас эхэлж зарцуулах аргыг ашигладаггүйгээс өмнөх оны үлдэгдэл	1	649.9						1	649.9

зарцуулаагүй үлдэж, хугацаа дууссан байна								
зардлыг эдийн засгийн ангиллаар нь зөв тайлагнаагүй	1	3,448.5					1	3,448.5
Дүн	3	4,607.6					3	4,607.6

Хүснэгт 8. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	541,847.9					1	541,847.9
Дүн	1	541,847.9					1	541,847.9